



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/164

Батширээт сум

Тамхины тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 16.3.4, Тамхины хяналтын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Худалдааны газрын стандартын шаардлага хангасан, Ерөнхий Боловсролын Сургуулийн 500м тойргоос гадагш байрлах “АНУ” дэлгүүрт (Иргэн СБ58063008 Б.Цогзолмаа-д тусгай зөвшөөрөл сунгах) тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг олгосугай.

2. Дээрх газарт олгох тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг төсөвт төвлөрүүлэхийг Татварын Улсын Байцаагч (Э.Цацрал)-д даалгасугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Хэсгийн төлөөлөгч, Цагдаагийн дэслэгч (Р.Болор-Эрдэнэ), Норовлин багийн Засаг дарга (Б.Бадамгарав) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232501521